

ЭРДЭНЭ ШАНЗУДБА ЛУВСАНГОНЧИГИЙН ТУХАЙ

Л.Алтанзаяа (Ph.D)

Түүхийн тэнхим
НХУС. МУБИС

Түлхүүр үгс: Хутагт, Эрдэнэ шанзудба Лувсангончиг, хүрээ сайд, Жавзандамба хутагт.

Товч утга: Төвд лам Лувсангончиг XIX зууны эхнээс Жавзандамба хутагтын хүрээ болон шавийн асуудалд оролцож эхэлсэн нь Манж, Төвд, Монголын харилцаатай холбоотой. Бидний судалгаагаар Манжийн төрөөс Жавзандамба хутагтын сойвонг ажиллуулсан Лувсангончиг бээр 1807 онд Эрдэнэ шанзудба болж, улмаар 1811 он хүртэл ажилласан нь тогтоогдож байна. Түүний удаан хугацаанд Хүрээнд ажилласан байдал нь Эрдэнэ шанзудба болоход нөлөөлжээ. Түүний ийнхүү Эрдэнэ шанзудба болсон нь Хүрээ сайдын үйл ажиллагаатай ч нягт холбоотой. Манжийн Сайшаалт Ерөөлт хааны үеэс (1796-1820) тогтсон Манж болон Халх Монголын зарим ноёдын ойр дотно харилцаа нь бас түүнийг Эрдэнэ шанзудба болоход нөлөөлсөн гэж үзэж байна.

* * * * *

Монголын бурханы шашны түүхийн талаар олон эрдэмтэд судалсан. Монголын хаад ноёд Юань улсын үеийн Төвдийн бурханы шашныг тэтгэж байсан уламжлалыг сэргээн XVI-XVII зуунд Төвдийн томоохон лам нарт Далай лам, Банчин хутагт цол олгож бусад талаар дэмжив. Монголын нийгэмд лам нар хэмээх шинэ давхарга үүссэн бөгөөд Халх аймагт 1639 онд өргөмжилсөн Түшээт ханы хүү Жавзандамба хутагт нь Халхын хаад ноёдын төдийгүй Манжийн хааны дэмжлэгийг олсноор хожим Далай лам, Банчин хутагтын дараах дээд лам болсон юм. Монголын хутагт лам нарыг эртний Энэтхэг, дараа нь Төвдөд төрөл арилжин тодорсон лам нарын хувилгаан буюу шинэ дүрүүд хэмээж байв.

Халхын томоохон хутагт лам нараас харьяат шавь нараа захирах хэлбэр XVII зуунд үүссэн ба Манжийн эрхшээлд орохоос өмнө нэгэнт тогтсон ёстой болжээ. Шавь нар гэдэгт хутагтын сүм хийдийн лам нар хэмээх шар шавь нар болон аж ахуйг нь эрхэлдэг харьяат хар шавь нар хэмээх хүмүүс багтана. Тэдгээр шавь нарын хэргийг эрхлэх тушаалтныг шанзудба хэмээдэг. XVII-XX зууны эхэн үеийн Монголын түүх судлалд Халхын Жавзандамба хутагтын шавь нарын захиргааны асуудал зохих байр суурийг эзлэх бөгөөд 1639 оноос Жавзандамба хутагтын шавь нарын түүх эхэлнэ.

Бид энэхүү бэсрэг өгүүлэлд Жавзандамба хутагтын сойвон байсан төвд лам Лувсангончигийг Сайшаалт ерөөлтийн 12-р буюу 1807 онд Эрдэнэ шанзодба болгоод Манжийн хааны зарлигаар зарсан Хүрээнд сууж хэрэг шийтгэгч сайд ван, сайдтанаас тушааж сургасан үгтэй холбогдуулан Жавзандамба хутагтын Хүрээ болон нийт шавь нарыг захирах хэрэгт Хүрээний төвд лам нарын төлөөллөөс хэрхэн оролцож байсан асуудлыг тодруулж, Монголын бурханы шашны төдийгүй нийгмийн харилцааны түүхэнд зарим төвд лам нар чухал үүрэгтэй оролцож байсан түүхэн нөхцөл байдлын талаар саналаа дэвшүүлэхийг зорисон болно.

XVII-XX зууны эхэн үеийн Монголын бурханы шашны түүхэнд Төвдөөс залж ирсэн олон арван эрдэмт хутагт, хувилгаан лам нар чухал үүрэг гүйцэтгэснийг үе үеийн эрдэмтэд судлан зохих дүгнэлт өгсөн. Уг судалгааг улам лавшруулан Жавзандамба хутагтын Хүрээ болон Халхын хошуу, шавиудад аж төрж байсан төвд лам нарын болон тэднийг дагалдан суусан энгийн хүмүүсийн түүх, намтар, бүтээл туурвил, үйл ажиллагааны түүхийг улам тодруулах шаардлага урган гарч байна. Хүрээний Хамба номун ханы тушаалыг хэд хэдэн төвд лам нар хашиж байсан бол дэд хамба, Эрдэнэ шанзудбагийн тушаалд тус бүр нэг удаа төвд лам нар ажиллаж байсан юм.

Тэр тухайд Монголын эрдэмтэн Ө.Сэрээтэр бүтээлдээ “Жавзандамба хутагтын сойвон байсан Лувсангончиг хэмээх түвд лам 1807-1811 онд Эрдэнэ шанзодбын тушаалтай байгаад эрүүл мэндийн шалтгаанаар чөлөөлөгджээ. Лувсангончиг язгууртны гэрээс гаралтай тул түүнийг Эрх тойн, дархан ноён гэхээс гадна Ачит, Билэгт, Эрдэнэ, Цэцэн далай зэрэг цол гуншинтай байжээ”¹ хэмээн бичсэн нь зохих ач холбогдолтой юм.

Эрдэнэ шанзудба Лувсангончиг хэчнээн лам шавь нарыг хамааран захирч байсныг тоймлон үзье. 1800 оны байдлаар Жавзандамба хутагтын шавийн харьяат нарын өрх 15680, хувраг 17561, хүн ам 82408, адуу 268365, тэмээ 34743, үхэр 269482, хонь, ямаа 1235634 байв.²

1800-1825 онд Жавзандамба хутагтын харьяат лам нар 17561-аас 27779 орчим байсан бөгөөд Халхын төдийгүй Монголын хүрээ хийдүүдийн дотроос хамгийн олон ламтай нь Их хүрээ байжээ. Тийнхүү Жавзандамба хутагтын лам нар, хар шавь нарын хувьд тоогоор тэргүүлж байсан үед буюу 1807 оны зун Манжийн хааны зарлигаар төвд сойвон лам Лувсангончигийг шанзудба болгож тамгыг шилжүүлжээ.

Тухайн үед Эрдэнэ шанзудба нь нэг талаас Манжийн хааны зарлигаар тавидаг томоохон албан тушаал, нөгөө талаас Жавзандамба хутагтын шашны үйлсэд туслан лам, хар шавь нарыг захирдгаараа онцгой байр суурьтай байв. Түүнээс өмнө болон хойно Эрдэнэ шанзудбагийн тушаалд монгол хүмүүс

¹ Ө.Сэрээтэр. *Монголын Их хүрээ, Гандан хийдийн түүхэн бүтэцийн товч*(1651-1938). Улаанбаатар. 1999.125-р тал.

² Д.Цэдэв. *Их шавь*. УБ.,1964.91-р тал.

ажиллаж байсан бөгөөд Лувсангончигийг уг тушаалд ажиллуулах болсон учрыг тодотгууштай юм.

Эрдэнэ шанзудба Лувсангончиг нь Жавзандамба хутагтын дэргэд 30 илүү жил болсон тул Хүрээний нөхцөл байдал хийгээд халх монголчуудын талаар тодорхой мэддэг байсан нь түүнийг уг тушаалд ажиллуулахад нэг хүчин зүйл болсон ажээ. Хүрээний онцлогийг тодруулахын тулд 1770-аад онд Лувсангончиг Төвдөөс Халхын Жавзандамба хутагтын хүрээнд ирснээс өмнөх үед нөхцөл байдал ямар байсныг товч тодруулъя.

Эрдэнэ шанзудба Лувсангончигөөс өмнөх үеийн байдал. 1639 оноос Жавзандамба хутагтын шавь нарын түүх эхэлдэг бөгөөд анх байгуулсан 12 отог нь нэмэгдсээр 17 отог болсныг их отог хэмээн ялган нэрлэдэг. Тэдгээр отгууд нь

Халхын Түшээт хан аймгийн зарим хошуудын нутагт тархан оршиж байжээ. Тэдгээр их отгууд хуваагдан олширсон хэмээн зарим судлаачид үзсэн. Харин бидний үзэхээр их отгуудын зэрэгцээ бага отгууд нэмэгдсэн олширч байв. Мөн Сэцэн хан аймгийн хошуудаас олон шавь өргөсөн байна.

Урьдын судалгаанд отгуудын захиргаа, албан тушаалтнуудын талаар дурдсан боловч хэрхэн отгийн дарга болдог талаар тайлбарласан нь ховор байна. 1763 онд Жавзандамба хутагтын шавийн 25 отгийн дарга нарыг Хүрээнд цуглуулахад тэдний хагас нь хөвгүүд дүү нарыг залгамжлан тависан, хагас нь сонгогдож отгийн дарга болсон байв. Тухайн үед Жавзандамба хутагтын шавь нарын хэргийг Манжийн хааны зарлигаар томилсон Хүрээнд сууж хэрэг шийтгэгч сайд хамаарах болсон нь отгийн талаар анхаарахад хүргэжээ. Тийнхүү шавийн шашны хэрэг хамаарсан Номун хан, шавийн хэргийг хамаарсан Эрдэнэ шанзудба нар шийдсэн аливаа хэргийг Хүрээний сайдад айлтгаж байхаар болжээ. 1772 онд отог болон баг(захиргааны нэгж) нийлээд 60 орчим болсон нь хошуудаас шавь нар олноор өргөснөөр 1764-1773 онд шавь нарын өрх 42%, хувраг 34%, хүн ам 18% нэмэгдсэнтэй холбоотой юм. Хүрээний сайдын бас нэг үүрэг нь худалдаачин хятадуудын хэргийг захиран шийтгэх явдал байв. Иймд хошууны нутагт аж төрдөг шавь нар болон хятад худалдаачдын хооронд өр авлагын асуудал гарахад Эрдэнэ шанзудбагийн захиргаагаар дамжуулан шийддэг байв. 1808 онд хятад худалдаачдын өрөөс гарахын тулд Жавзандамба хутагтын шавьд гэрийн хүн(зарц)-ийг өргөж мөнгө, мал зээлэхийг хүссэн явдал гарч байсан нь урьдын судалгаанд дурдагдаж байгаагүй өвөрмөц хэлбэр ажээ.

Улмаар 1818 он гэхэд 17 их отгийн зэрэгцээ бага отгууд (отог ба баг) нь 73 болсон бөгөөд харин 1820 онд Жавзандамба хутагтын харьяат шавь нарын бүгд хүн малыг байцаасан бичигт өрх, лам, хүн ам, малыг их отгууд буюу 17 отогт хуваан бичсэн нь сонирхол татаж байна. Учир нь тэрхүү дүнг Хүрээний сайдад мэдүүлдэг байсан бөгөөд уг малын дүнг үндэслэн алба оноодог байжээ. Шавь нар тэднийг анх өргөсөн хошуундаа байдаг тул хошууны харьяат болон шавь нарын хоорондын нутаг бэлчээрийн маргааны хэргийг Эрдэнэ шанзудбагийн газар, хошууны тамгын газартай харилцан шийдвэрлэдэг байв. Харин шавь нарын тоо буурсан ч отгуудын тоо нэмэгдсээр байсан нь отог тус бүрийн хүн амын тоо их

бага харилцан адилгүй байж болдгийнх юм. Ийнхүү Хүрээний сайдын хувьд Жавзандамба хутагтын шавь нарын хэргийг шийтгэхэд оролцох нь хязгаарлагдмал байсан тул отгууд улам олширч уламжлалт зохион байгуулалт хадгалагдсаар ХХ зууны эхэн үе хүрсэн байна.

I Жавзандамба хутагт Лувсандамбийжанцан(1635-1723)-ийн үеэс Хүрээнд төвд хүмүүс амьдарч байсан бөгөөд 1751 оны нэгэн мэдээ анхаарал татаж байна. Уг баримтад тэмдэглэснээр, 1751 онд Жавзандамба хутагтын хүрээнээс Төвд рүү явах тангуд буюу төвд хувраг 11, монгол хувраг 21, монгол хар хүн 19, тангуд хар хүн 2 байв. Эдгээр 53 хүний замдаа хэрэглэх монгол гэр 7, майхан гэр 8, тогоо 18, тулга 12, саадаг 27, буу 14, сэлэм 15, тэмээ 189, морь 348 байжээ. Харин Манзушир хутагтын шавь нараас явах 62 хүний дотор төвд хувраг 22, монгол хувраг 25, хар хүн 15 байв. Тэдгээр 62 хүний замд хэрэглэх монгол гэр майхан 18, тогоо 19, тулга 18, саадаг 31, буу 9, сэлэм 11, тэмээ 109, морь, луус 406 байжээ. Түүнчлэн засгийн тэргүүн зэрэг тайж Дашпилийн хошуу(Халхын умар замын зүүн гарын умард хошуу)-наас явах 28 хүний дотор монгол хувраг 11 байсны дээр 45 настай тангуд гэлэн Лувсанданзан байв. Тэдгээр 20 хүний хэрэглэх монгол гэр 3, майхан 4, буу 6, саадаг 7, сэлэм 5, тогоо 9, тулга 4, сүх 4, царил 5, хүрз 5, тэмээ 95, морь 23 байв. Нийт 135 хүний дотроо тангуд монгол хувраг 91, тангуд монгол хар хүн 44, эдний нийт гэр майхан 40, тогоо 46, тулга 34, саадаг 65, буу 29, сэлэм 31, тэмээ 393, морь луу 777, сүх 4, царил 5 хэмээн бүртгэжээ. Тэдгээр 135 хүний дотроос Төвдөд очоод тэндээ үлдэж бүр суух нь Жамцандурал, Лувсангэлэг, Чүлтэмжамц нарын 13 хувраг, Дондов, Ринчин хэмээх 2 хар хүн байв. Харин бусад нь бүгд буцаж ирэхээр бичжээ.³ Иймд тухайн үед 19-60 насны 34 төвд хувраг, 2 хар хүн явсны 13 хувраг, 2 хар хүн нь Төвддөө үлдэж бусад 21 хувраг нь буцаж ирэхээр болж байжээ.

Энэхүү мэдээний сонирхолтой тал нь Жавзандамба хутагтын хүрээ, Манзушир хутагтын шавь, засгийн тэргүүн зэрэг тайж Дашпилийн хошуу(Халхын умар замын зүүн гарын умард хошуу) хошуунд цөөн боловч төвд лам нар аж төрж байсан төдийгүй Халхаас Төвдөд очоод буцаж ирж байсан явдал юм. Энэ нь зөвхөн нэг удаа Төвд рүү явахтай холбоотой тэмдэглэл төдий бөгөөд нэр дурдагдаагүй бусад төвд лам, хар хүмүүс байсан эсэхийг тодотгууштай. Иймд уг данс нь II Жавзандамба хутагт Лувсандамбийдонми (1724-1758)-ийн үед шашны харилцаанаас үүдэн Халхад биеэр ирж шашин ном дэлгэрүүлж байсан төвд лам нарын суурьшил байсныг гэрчлэх баримт юм. Уг дансыг “Түшээт ханы аймгаас Баруунтаа очих улсын хуамин данс” хэмээн гарчигласны учир хамаарлыг лавлан үзүүштэй юм.

Тухайн үед буюу 1743-1754 онд Эрдэнэ шанзудбагаар Пунцагяримпил байсан бөгөөд 1754-1764 онд Түшээт ханы ойр удмын лам тайж буюу тойн Сүндэвдорж Эрдэнэ шанзудбагийн тушаалд ажиллаж байв. Тэрбээр чуулганы дарга Дашпилын хамтаар Түшээт ханы хүчийг төлөөлж, Хүрээг тойрсон асуудлаар Цэнгүнжав, Сайн ноён Дэчинжав зэрэг ноёдтой нэгдэж нийлж Манжийн талыг

³Монгол улсын үндэсний төв архив. ФМ№9. Д-1. ХН-4.

баримталсан Санзайдоржтой тэмцэж байсан ажээ. Харин Санзайдоржийг Түшээт хан аймгийн туслагч жанжны хэбэй Сандавдорж, Хүрээний Хамба номун хан Жамбалдорж, сойвон Дансүрэн нар дэмжиж байв.⁴ 1764 онд “хойргошсон” хэмээн тамгыг шилжүүлэв.

1764-1765 онд Гомбодорж, 1765-1770 онд Гарамцэрэн нар Эрдэнэ шанзудбагийн тушаалд ажиллаж байв. XVII зууны үеэс Халх Монголд нэвтэрч байсан төвд лам нарын Хүрээн дэх суурьшил нь Жавзандамба хутагтын дүрүүдийг Төвдөөс тодруулан залах болсноор улам нэмэгдсэн бололтой. Халхын Түшээт хан Гомбодоржийн 3-р хүү I Жавзандамба хутагт Лувсандамбийжанцан (1635-1723) болон Түшээт хан аймгийн чин ван Дондовдоржийн хүү II Жавзандамба хутагт Лувсандамбийдонми (1724-1758) нараас хойш дараагийн дүрүүдийг Төвдөөс тодруулах болов. 1758 онд III Жавзандамба хутагтыг Далай ламын зарлигаар тодруулан Төвдийн түшмэл Данзангомбын хүү Ишдамбийням (1758-1773)-ыг 1763 онд ширээнд залжээ. Түүний дараа IV Жавзандамба хутагтаар 1781 онд Сономдашийн хүү Лувсантүвдэнваанчиг (1775-1813)-ийг ширээнд залав.⁵

1770-1807 онд Эрдэнэ шанзудба Дамчойравжаа алба хашиж байсан бөгөөд төвд, монгол бичгийн өндөр боловсролтой лам байжээ. Хүрээний сайд хуучин Эрдэнэ шанзудбатай сайн харилцаатай байдлаа шинэ Эрдэнэ шанзудбагийн үед ч үргэлжлүүлэх сонирхолтой байв. Жавзандамба хутагтын өргөөнд тэргүүлэх эрх бүхий 2 сойвон, 4 донир байсны 1 донир нь Дамчойравжаа байж байгаад Эрдэнэ шанзудба болсон юм. Түүний дараагийн Эрдэнэ шанзудба болох Лувсангончиг ч Жавзандамба хутагтын сойвон байсан ажээ.

Хүрээ сайдаас Лувсангончигтой харилцсан байдал. 1807 онд Хүрээнд сууж хэрэг шийтгэгч сайд ван, сайдтанаас Жавзандамба хутагтын шавь нарыг чандлан захирах явдлыг чухалчлан Да лам Лувсанжамба, Гомбожав нарын дэргэд Эрдэнэ шанзудба Лувсангончигт тушааж ухуулан сургаж хэлсэн нь тэмдэглэгдэн үлджээ.

Тухайн үед Хүрээний сайдаар Халхын умар замын дундад дахь баруун этгээдийн хошууны засаг ван Юндэндорж ажиллаж байв. Манжийн хаад нь ураг төрлийн эмэгтэйчүүдийг (гүнж) Монголын ноёдын гэргий болгон өгч ураг андын холбоогоор эзэрхийлэх эрхшээлээ бэхжүүлэв. Тэдгээр үрс тайж, ураг төрлийн угсааны тайж нар олширч 1805 оны байдлаар 400 гаруй хүн, 1839 онд 2000 орчим хүмүүс болон олширч байв.⁶ Ван Юндэндоржийн хувьд тэр талаар Халхын бусад ноёдоос ялгарах онцлогтой байсан бөгөөд түүний эцэг Санзайдорж нь Тэнгэрийн тэтгэсэн хааны итгэлт хүн байсан билээ. Иймд Тэнгэрийн тэтгэсэн хаан, Хүрээний сайд, ван Санзайдорж нараас Жавзандамба хутагтын шавь нарын захиргааг эрхшээх замаар Түшээт ханы эрх мэдэлд нөлөөлж байв. Сайшаалт ерөөлтийн үед

⁴ Ока Хироки. Цэнгүнжав ба Санзайдорж //Сайн ноён хан аймгийн Сэцэн чин вангийн хошууны түүх, соёлын судалгаа. Улаанбаатар. 2018. 231, 239-р тал.

⁵ Ө.Сэрээтэр. Монголын Их хүрээ, Гандан хийдийн түүхэн бүтэцийн товч(1651-1938). Улаанбаатар. 1999.90-93-р тал.

⁶ Ж.Самбуу. Шашин ба лам нарын асуудалд. УБ.,1961.43-р тал.

ван Юндэндоржоос айлтган төвд сойвон Лувсангончигийг Эрдэнэ шанзудба болгосон ажээ.

Хүрээний сайдын газраас нугалбар айлтгаснаар Манжийн хаан буюу “Манзушир Богд эзэн” зарлиг буулгасны дагуу хуучин шанзудба Дашчойравжайгийн барьсан тамгыг шинэ шанзудба Лувсангончиг сөгдөж хүлээн авчээ. Шанзудба болох нь Манжийн хааны хишиг бөгөөд хоёрдугаарт Жавзандамба хутагтад туслан, шашны үйл, лам хар шавь нарыг чандлан захирах тушаал гэдгийг тодотгожээ. Лам Лувсангончигийг “төвд хүн боловч багаасаа Гэгээнээ сувилж 30 илүү он болов. Эндэх халх монголчуудын сайн муу зан суртлыг үл мэднэ гэх явдал үгүй” хэмээн онцлоод Эрдэнэ шанзудбагийнх нь хувьд анхаарах хэдэн зүйлийг дурджээ. Үүнд,

1. Шавь нарын хуучин сайн суртлыг дагаж, олны санааг дагуулах 2. Жавзандамба хутагтад зохистой үг санааг сануулан явах 3. Шашны үйлийг Номунхан нартай хамтран өмөөрөх, хэлбэрэх сэтгэлгүй болгон дэлгэрүүлэх 4. Шавь нарын хэрэг, заргыг засаг ба хоёр да лам, зайсан лам нарын санааг авч шийтгэх 5. Хүрээний сайдын “харьяат захирах ард” тул тулгамдсан хэргийг өөрөө очиж асуух 6. Аливаа аймаг, чуулганы дарга нар, хошууд, хан, ван, бэйл, бэйс, гүн, засгуудтай бүгдээр нийлж хэрэг шийтгэвээс нэн нарийвчлан хянаж шийтгэх 7. Хуучин шанзудбагийн сайн явдлыг дуурайж явах 8. Хуучин шанзудбагаас илүү сайн байх гээд бүү зөөлдүүлэхэд хүргэ 9. Жавзандамба хутагтын дэргэд “Богд Манзушир Бурхан эзэн”-ий зарлигийг дагаж “шударга шулуун сайн” хүнийг сонгож явуулагтун. 10. Сойвон, донир, тахилчин ба сул дагагчид, соёгба зэрэг тушаалтныг Хүрээний 26 аймгийн дотроос давхцуулахгүй сонгож талбих 11. Жавзандамба хутагтын дотоод гадаад сангийн нярав лам нарыг “номхон сайн шударгуу”-г эрж сонгож явуулах 12. Аливаа зүйлийг бүгдээр хянан хэлэлцэж бас Жавзандамба хутагтаас лавлаж явуулах хэмээжээ.

Эрдэнэ шанзудба нь ламын хувьд Хүрээний аль нэгэн аймагт харьяалагддаг байсан тул сойвон, донир, тахилчин ба сул дагагчид, соёгба нарыг тавихад харьяат аймгийг харгалзсан нэр авахаас сэрэмжилдэг байв. Улмаар “Шанзудба чи төвд хүн. Олон төвд хүн энд ирсэн нь хөөрхий. Хэвээр хуучин ёсоор харгалзаж байгтун. Төвд шанзудба талбив хэмээн дэмий төвдүүдийг давруулбаас бас ч үл болмуй. Төвд нарыг хэтэрхий өмөөрөн харгалзвал хэмээх нэр бүү авагтун” хэмээн анхааруулжээ.

1805 онд Их хүрээний Дүйнхорын сургуулийн дацан байгуулан олон зүйлийн хурал эхэлж хурав.⁷ Иймд Жавзандамба хутагтын ном хурал нэмэгдсэн хэдий ч хутагтын сан ба олон шавь нарын хүнийг арвилж зохицуулахыг даалгажээ. Бас хэтэрхий наймаа хийх, Хүрээний банди нар хэсэх ба хэрүүл зодоон хийх зэргийг чандлан цаазлаж, “өөрийн явах зорчих зүйлд хуучин шанзудбаг дуурайгтун” хэмээв. Мөн Баруун Хүрээний зарим отгийн ардуудыг чандлан захирах, эс бол захиргааны ардын талаар буруушаан айлтгаад хүндэд яллахыг

⁷ Мөн тэнд. 45-р тал.

сануулав. Ялангуяа “Олны гаслалцахаас үл эмээх нь чухам дээр нь улс төрийн хэрэг, хоёрдугаарт гэгээн бурхан шажинаа тустай болвоос, хэний гаслалцахаас эмээлгүй. Сайн хүнд сайн хэмээгдэх болоод муу хүнд жигшигдвээс сая сайн шанзудба болмуй. Сэцэн ба мунхагуудыг хамтатгаж нийтээр сайн хэмээгдвээс сайн дор тооцож болохгүй болой” хэмээсэн нь анхаарал татна.

Тийнхүү сайд нарын сурган тушаасныг тэмдэглэсэн бичигт “Хүрээнд сууж хэрэг шийтгэх сайдын тамга” даржээ.⁸ Уг тамгыг 1802 онд Манжийн хааны зарлигаар хэрэглүүлсэн юм.

Эрдэнэ шанзудба Лувсангончигийн үйл ажиллагааны тухай. 1807-1811 онд Эрдэнэ шанзудба Лувсангончиг хэрхэн ажилласан талаар зарим жишээг үзье. Тухайн үед Хүрээний Хамба номун ханы тушаалд Их шавийн Мэргэн хамба хутагт Жанчивдорж, цоржийн тушаалд Жамц, Сономцэрэн нар ажиллаж байв.

1808 оны 3 сарын 30-нд Хүрээ сайдад өргөсөн бичигт дурдсанаар Лувсангончигийг Манжийн хааны зарлигаар байгуулсан Амарбаясгалант сүмийг эргэж үзэх ба өвчнөө эмчлүүлэхээр зөвшөөрөл авсан үед тамгыг Да лам Лувсанжамба түр хамаарч, хэрэг шийтгэж байсан бөгөөд буцаж ирээд тамгыг хүлээн авч хэрэг шийтгэдэг байжээ.⁹

1808 оны 4 сарын 20-ны Эрдэнэ шанзудба Лувсангончиг, Да лам Лувсанжамба, Гомбожав нараас Хүрээний сайдад өргөсөн бичигт дурдсанаар Сангийн хэргийг захиран суусан Сэцэн хан аймгийн засгийн тэргүүн зэрэг тайж Чивагжав нь тус оны 3 сарын 21-нд өвчнөөр нас барсан явдлыг мэдүүлээд хэнээр Сангийн хэргийг захиргах явдлыг лавласан байдаг. Мөн уг бичигт Сангийн хэргийг Эрдэнэ шанзудба хамтаар захирах тухай дурджээ.¹⁰ Тийнхүү Сангийн хэргийг тайж ноёнтон хамтран захирч байсан нь дээр дурдсан сургах бичгийн агуулгатай тохирч байна.

1808 оны 5 сарын шинийн 6-ны бичигт дурдсанаар, 1807 оны 5 сарын шинийн 5-нд Эрдэнэ шанзудба Лувсангончиг Манжийн хааны зарлигаар шанзудбагийн тамга хүлээж аваад хуучин шанзудба Дашчойравжаваас хэрэг шийтгэж байсан дансыг авчээ. Амарбаясгалант хийд, Шашныг бадруулагч сүмийн юм зүйл болон Жавзандамба хутагтуудын юм зүйлсээс Төвдөд явахдаа өргөж баридаг байсан аж. 1806 онд Манзушир Богд эзэн түмэн өлзий үүрд батдахын тул, Дүйнхэр бурхан бүтээж тахихад алтадсан дээвэр туургатай хэмээх нэгэн дуган шинэ байгуулж хурал ном үйлдүүлжээ. Мөн хутагт нарын бурхан тахилын эд алт мөнгө өглөг элдэв зүйлийн савнуудыг сэлбэж шинэтгэж байв. Харин хааны шагнасан юм ба сангийн юмгүй болсон байв. Хутагтуудын навсаас өглөгийн эзэд шүтээн болгон залж тахисан бөгөөд өглөгийн эздийн барисан хувцас хунар, эмээл, хазаар, бусад зүйлийг жил бүрийн эцэст Богд эзний түмэн өлзий гүрэм жилийн жасаа ном уншуулсан олон лам нарт барьц болгон өгдөг байжээ. Сангийн юмсаас

⁸ Монгол улсын үндэсний төв архив. ФМ№1. Д-1. ХН-3414. 31-р.

⁹ Монгол улсын үндэсний төв архив. ФМ№1. Д-2. ХН-219. 12-р.

¹⁰ Монгол улсын үндэсний төв архив. ФМ№1. Д-2. ХН-213. 30-р.

зараад бүртгэсний дээр шинэ нэмэгдсэн тахилын мөнгөн зүйлийг нэмж бичээд 1770 онд хуучин шанзудбагийн байцааж үйлдсэн тамгат данстай харшуулан байцаасан байна. Тэгээд тамга дарсан дэвтэр данс 1 хувийг үйлдэж Хүрээний сайдад өргөжээ.¹¹ Ялангуяа тэрхүү дэвтэр дансыг Хүрээний сайдад танилцуулсан нь сонирхолтой юм.

1808 оны 8 сарын 13-нд Эрдэнэ шанзудба Лувсангончигоос “өчүүхэн Лувсангончиг би энэ жил нийслэл хотноо орон Тэнгэрийн гэгээнээ бараалхан түмэн амгаланг эрж хишигт мөргөхийг чин үнэнээр хүсэн” байгаагаа мэдүүлэв. Жавзандамба хутагтын Хүрээний шашны хэргийг эрхлэсэн Хамба номун хан нь Эрдэнэ шанзудбатай ээлжлэн жасаанд орж Манжийн хаанд бараалхдаг байжээ. Иймд Хамба номун хан Жанчивдоржтой жасаалах ээлжинд тохиолдуулан тогтоохыг гуйсан байна. Харин явахдаа шанзудбагийн тамгыг гүнгийн зэрэг засаг Гүнсэнбамбарт шилжүүлж хамааргахыг мэдүүлж байв. Тийнхүү тэрбээр 10 сарын 13-нд Хүрээнээс даруй мордохоор болсон явдлыг болон шинэ тамгыг Гүнсэнсамбарт түр хамааруулаад, да лам Лувсанжанцан, Гомбожавын хамт хэрэг шийтгүүлэх болсон явдлыг мэдүүлжээ.¹²

Шанзудбагийн тамгыг Сангийн хамаг хэргийг байцаан захирах засаг засаг ноёнд шилжүүлдэг нь Жавзандамба хутагтын шавийн захиргааны нэгэн онцлог болно. Гэхдээ уг ноён нь да лам нартай хамтран хэрэг шийтгэж байв.

1808 оны 11 сарын 27-нд Эрдэнэ шанзудба Лувсангончог Бээжинд очсон бөгөөд 28-нд ГМТЗЯЯ-нд мэдээгээ өгөв. Тус сарын 30-нд сайд Дагвийжамцан чухал тойн, түнш Цэдэндаш нарыг ГМТЗЯЯ-нд зарж ямар дэвсгэр, ямар тэргээр явбал зохих зэрэг явдлыг лавлахаар илгээсэн бөгөөд шилүүсэн дэвсгэр, ногоон бүрээстэй тэрэг хэрэглэж явахаар болжээ. Түүний биеийн байдал тавгүй болсон учир бичээч Навааныг илгээж мөн сарын 15-нд зөвшөөрөл бичгээр олж Хүрээний зүг буцжээ.¹³

Лувсангончиг нь шавь нарын нутгийн хэргийг журам тогтоон шийдвэрлэхээр оролдож байв. Жишээ нь, 1810 оны 9 сард Эрдэнэ шанзудба Лувсангончиг нараас Хүрээний сайдад мэдүүлсэн байдаг. Үүнд, “Жавзандамба хутагтын шавь нарын ардыг язгуураас Халхын дөрвөн аймагт нийгэмчлэн нутаглуулмуй” хэмээн тогтоосны дагуу хүрэлцэхийг үзэж Түшээт хан, Сэцэн хан, Сайн ноён 3 аймгийн олон хошуудын нутагт олон цөөхөн адилгүй хольцолдон нутаглуулсаар ирсэн. Харин жилийн зуд тохиолдож шавь нарын ард хуучин суусан газраас нүүж, холын нутагт очвол зарим хошуу хүлээн авч нутаглуулахгүй байх ба тогтоосон нутгаас хомстгоход хүрсэн нь бас байдаг. Иймд үүнийг “нэгэн журам тогтоолгоё” хэмээжээ. Харин Хүрээний сайд, шавь нарын ардын олон отог бүр язгуураас тус тус олж оршин суусан уул нутгийн газар нутгийг газар буй тул тэднийг 1772 оны үед нутаглуулж явсан мөнхүү хуучин хэвээр нутаглан суулгахыг заажээ. Хэрэв зуд тохиолдоод шавь нарын ардыг шилж өөр газарт нүүж нутаглах үед Шанзудба

¹¹Монгол улсын үндэсний төв архив. ФМ№1.Д-2. ХН-219. 14-р.

¹²Монгол улсын үндэсний төв архив. ФМ№1.Д-2. ХН-213. 36-р.

¹³Монгол улсын үндэсний төв архив. ФМ№85.Д-1. ХН-57.

нарын газраас магадлан байцаагаад, аль аймгийн хэний хошууны нутагт илгээх талаар бичиг явуулаад “найртайгаар нутаглуул” хэмээв.¹⁴

Учир нь 1806 онд Халхын 4 аймгийн нутгийг байцаан зураг цэс үйлдэж ГМТЗЯЯ-нд мэдүүлэхэд шавь нарын ардын суусан байдал төлвийг шанзудбагаас мэдүүлсэн бичигтэй нийлэлцсэн байжээ. 1810 оны 11 сарын 29-нд Хан уулын чуулгын дарга Түшээт хан, Хэрлэн барс хотын чуулгын дарга ван нараас Эрдэнэ шанзудба нарт дараах бичгийг илгээв. Уг бичигт, 1807 онд Жавзандамба хутагтын шавь нарын ард их цас зуд тохиолдоод нутаг сонгож Түшээт хан аймгийн засаг Үржинжав, Сэцэн хан аймгийн жанжин бэйл Намжилдорж нарын нутагт нүүж хүрсэн хэрд тэдний хошуу шавийн ард бэлчээрийг тэмцэн харилцан цуугилдсан хэргийг дурджээ.

Улмаар 3 аймгийн чуулганы дарга нар зөвшин хэлэлцсэн байна. Шавь нарын ард нь Халхын 4 аймгийн олон засаг хошууны дотроос шавь болж тэдний нутаглах газарт язгуураас тогтоосон захгүй байв. Учир нь Жавзандамба хутагт болвоос 4 аймгийн тахисан блам тул, хүндлэх ёсыг дагуулан, шавь нарын ардыг 4 аймгийн нутагт найртайгаар, хуучин ёсоор нутаглуулжээ. Тэдний нутаглах газрыг “Шавьд өргөв” хэмээн өөрчилсөнгүй. 1806 он Халхын 4 аймгийн нутаг орны байдал, төлөв, жич тогтоосон зах хэлхээг байцаан зураг цэс үйлдэж Улиастайн жанжин, Хүрээний сайдаар уламжлан Их Жургаанд мэдүүлэхэд шавь нарын ардын суусан хуучин байдал төлвийг шанзудба Дамчойравжаагийн мэдүүлсэн бичиг, олон хошуудын өргөсөн цэстэй харилцан нийлэлцсэн байжээ. Иймд 1772 оны үед нутаглуулж явсан хуучин хэвийг эвдэлгүйгээр Халхын аймгийн дотроо нийгэм нутагласан тул тийнхүү нэгэнтээ өргөн мэдүүлээд тогтоожээ. Иймд 4 аймгийн нутагт эртний хуучин хэвээр бариа хөөлгөгүй нутаглуулан суулгахаар тогтоод шавь нарын дарга Вамбу, Дансран, Цэсрэн, Гансүрэн нарын отогт зах нийлсэн Сайн ноён аймгийн бэйл Гомбоцэрэн, бэйс Доржбал, Цэвэгжал нарын хошуу ба Зая бандида хутагтын шавь нарт харьяат чуулганы дарга нарын газраас мэдэгдэн “хөөлгө бариагүй нутаглуулах”-ыг тушаасан байна. Мөн шавь нарын ардтай нутаг булаалдсан Түшээт хан, Сэцэн хан 2 аймгийн хэдэн хошуудад дор басхүү харьяат 2 аймгийн чуулганы дарга нарын газраас явуулаад хуучин ёсоор нутаглуулахаар хэлэлцжээ.¹⁵

Ийнхүү Эрдэнэ шанзудба Лувсангончигийн үед шавь нарын нутгийн асуудалтай холбогдсон чухал хэргийг дахин шийдвэрлэсэн байна. Түүний үед шавь нарын нутгийн хэрэгт хуучин ёсыг дагаж шийтгэж байсан ба шавь нарын харьяат газар тариалан эрхлэх нь үргэлжилсээр байв. 1811 оны 6 сард эрүүл мэндээс шалтгаалан тушаалаа өгсөн Лувсангончигт олгосон сургах зарлигийг тусгайлан хүн зарж ГМТЗЯЯ-нд хүргүүлэхээр болов.¹⁶

Дээр дурдсан зарим баримтыг үндэслэн бид дараах саналыг дэвшүүлж байна. 1807 онд Лувсангончиг Эрдэнэ шанзудба болсон нь бүр 1751 оноос

¹⁴ Монгол улсын үндэсний төв архив. ФМ№85.Д-2. ХН-255. 3-р.

¹⁵ Монгол улсын үндэсний төв архив. ФМ№85.Д-2. ХН-255. 2-р.

¹⁶ Монгол улсын үндэсний төв архив. ФМ№85.Д-3. ХН-164.

Хүрээнд суурьшсан төвд лам нарын төлөөллийн хувьд туршлагажсан байдал, Хүрээний сайдын эрх ашиг, үйл ажиллагаатай холбоотой байна. Сайшаалт ерөөлт хааны үед Халхын зарим ноёдтой харилцах уламжлал хадгалагдаж, Хүрээний сайдын эрх хэмжээ өөрчлөгдсөн нь Хүрээний лам нарын цөөнх болох төвд лам нарын төлөөлөгч сойвон Лувсангончигийг Эрдэнэ шанзудба болгох нэг хүчин зүйл болжээ.

Хүрээний сайдаас Эрдэнэ шанзудбад шууд зааварлаж сурган тушаасан бичгийг гаргасан нь тэдний харилцааны өөрчлөлтийг тусгасан баримт юм. Эрдэнэ шанзудба Лувсангончиг нь Хүрээний сайдтай байнгын харилцаатай ажиллаж байсан бөгөөд Сангийн юмсыг данслан бүртгэх чухал ажлыг дахин хийжээ. Түүний үед шавь нарын нутгийн хэрэгт хуучин ёсыг дагаж шийтгэж байсан ба шавь нарын харьяат газар тариалан эрхлэх явдал үргэлжилсээр байв. Ерөнхийдөө тухайн үед олон хэлбэрийн асуудал оршсоор байсан ч Жавзандамба хутагтын шавь нарын захиргааны хуучин зарчим хэвээр хадгалагдсаар байжээ. Уг асуудалд холбогдох бусад баримтыг харьцуулан нягталж цаашид улам гүнзгийрүүлэн судлууштай юм.

НОМ ЗҮЙ

1. Монгол улсын үндэсний төв архив. Ф№М1, Ф№М85
2. Ока Хироки. Цэнгүнжав ба Санзайдорж //Сайн ноён хан аймгийн Сэцэн чин вангийн хошууны түүх, соёлын судалгаа.Улаанбаатар. 2018.
3. Ж.Самбуу. Шашин ба лам нарын асуудалд. Улаанбаатар.1961.
4. Ө.Сэрээтэр. Монголын Их хүрээ, Гандан хийдийн түүхэн бүтэцийн товч (1651-1938). Улаанбаатар. 1999.
5. Д.Цэдэв. Их шавь. Улаанбаатар.1964.

ABSTRACT

According to our study, in the 1807 the Tibetan lama Luvsangonchig, who was soivon of Jebzundamba khutugtu by Manchu Qing emperor whom had became Erdene shanzudba and he had worked until 1811.

The Luvsangonchig was one of the Tibetan lamas who had live for many years in the Khuree. From this reason of the Luvsangonchig became Erdene shanzudba. Also it was related on activity of Khuree amban (governor). Traditional relation was saved between Khalkha Mongolian some nobles during Manchu Qing emperor Saishaalt eruult (Jiaqing) (1796-1820) and rule of the Khuree amban was changed that influenced to the Luvsangonchig became Erdene shanzudba.

The Khuree minister wrote commanded script to Erdene Shanzudba. This document is imaged reform of relation between Khuree amban and Erdene Shanzudba. But the administration rule of Jebzundamba khutugtu hadn't been changed.

The Tibetan lama Luvsangonchig was participated on action that Khuree and shabi of Jebzundamba khutugtu from beginning of XIX century. It is related on historical specific between Manchu, Tibet and Mongolian relation.

ЧИНГИС БОГДЫН ЗОХИОСОН СУРАГЧ АРДЫН УХААНЫГ ХӨГЛӨХ ОЮУНЫ ТҮЛХҮҮР¹

“Оюуны түлхүүр нэрт шастир оршивой”

Ум сайн амгалан болтугай.
Дээд лам гурван эрдэнэд мөргөмүй.
Эртний богдсын зохиосон шастрыг өчүүхэн сануулахын учир,
Эзэд хаадтан олныг хураая гэхүл өглөгөө өг.
Осолдолгүй явъя гэхүл түшмэдээ өргөх.
Аугаа хүчээ ихэтгээ гэхүл цэргээ асар.
Уужим сул жаргая гэхүл эеэ хичээгтүн.
Өдөр явсан явдлаа шөнө шүүгтүн.
Ичгүүр гэмт явдлыг хичээн ятгаж орхи,
Олны дотор үгээ бэхэл,
Ганцаар суухдаа сэтгэлээ шинжил,
Олон хүмүүн лугаа найран зохъ.
Ер авах гээхийн ялгалыг ихэтгэн
Егүүтгэлгүй сэтгэлийн угаас барьж,
Шажин амьтны тусыг хянамжлан санаж,
Хамаг амьтныг ганц хөвгүүн мэт хайрлан сургаж,
Эцэг мэт асар.
Эх мэт тэжээ.
Засаг цаазыг номын ёсоор барьж,
Сайн ардад өглөгөө хүртээж,
Олноо захир.
Олон амьтны тусад зохиож
Төрлийг энх амарт хүргэгтүн.
Үнэхээр гэмтэй хүмүүнийг гэсгээ.
Үнэнээр явагсдыг үзтэл өргөж хөгжөөгтүн.
Хэд хэдэн жилийн хэргийг нэгэн өдрийн хэрэг мэт хичээн бодож,
Төрийн хэрэг ба дайсны хэргийг адил болгон
Биеийн амрыг үл харан,
Бусдын үйлээс үл уйдан явбаас дээдсийн ойр гэх,
Асрахын урьд айлгах,
Албаттайгаа атаа тэмцэх
Ах дүүтэйгээ хэрүүлийг үүсгэх,
Дэмий холын хүмүүнд ханилан эвдрэх,
Дэргэдэх хүмүүнийг дэнсэлгэн зовоох,
Төрөл төрөгсөдөө үл амруулах
Төрийн цаазаас үл айх,
Муу хүмүүний үгэнд орох,
Сайн хүмүүний үгийг үл итгэх,

¹ Монгол бичгээс хөрвүүлсэн: М.Золзаяа, доктор (Ph.D), Монгол Улсын Соёл, урлагийн их сургууль, СУСХ. Япон улс, Мияаги муж. 2019 оны 1 дүгээр сарын 2-ны өдөр.

Ширүүн үгээр дайсныг хураах,
Хорт сэтгэлээр хамгийг хашруулах тэргүүтнийг тэвчигдэхүй.
Тойн хүмүүний эрдмийн дотор нигүүлсэхүй сэтгэл нэн эрдэм,
Хан хүмүүний гучин таван эрдмийн дотор хайрлах сэтгэл нэн эрдэм,
Хатан хүмүүний арван таван эрдмийн дотор сайхан ааль нэн эрдэм,
Түшмэл хүмүүний есөн эрдмийн дотор эв эе нэн эрдэм,
Тойн хамаг эрдмийг суравч
Дотроо нигүүлсэхүй сэтгэлгүй болбоос
Тоолшгүй эрдмийг суравч тун тусгүй.
Хаад хамаг эрдмийг хүсэвч
Хайрлах сэтгэлгүй болбоос
Хамагт эрхгүй хөнгөн болмуй.
Хатан хүмүүн хамаг сайхныг төгсөвч
Ааш муутай болбоос
Харин төрхөмдөө буг болмуй.
Түшмэл хүмүүн есөн эрдмийг суравч
Төвшин сайн эрдэмгүй болбоос
Хорт чоно мэт жигшигдэхийн тул
Төвшин сайн эеийг хичээ.
Ер хэн хүмүүн сайн үнэн үг,
Шударга явдлыг хичээн бэхэлж сурагтун.
Их бага заяатантай үзэн ядваас
Амны хишиг зайлах.
Өнчин хүмүүний жаргалыг хөнөөвөөс
Өөрийн хишиг эвдрэх.
Үнэн тус хүргэсэн хүмүүнийг муулваас үйл үл бүтэх
Үзтэл муулсан хүмүүнийг аргадваас тэнгэр үл таалах
Үзмэгц яаран бүү магт.
Түргэн зуур ханилсан нөхөрт бүү уурла,
Үргэлж ханилж тэнсэж мэд,
Нэгэнт учирсны хойдод яаран бүү цуцар.
Итгэсний хойно яаран үгээ бүү нуу,
Итгэлгүй нөхөрт ямагт зүрхний үгийг бүү хэл,
Муу хүмүүний үгэнд бүү ор.
Эм хүмүүний үгийг бүү дага.
Хөвгүүн ба боолд бүү мэдүүл.
Хартай хүмүүнтэй үг бүү зөвлө.
Олон хүмүүн зөвшсөнийг ганцаар бүү эвд.
Хилэнцэт үйлд бүү шуна.
Буянт үйлд бүү саад хий.
Үнэнээр барилдсан сайн үгсийг үхтэл бүү март.
Хагацашгүй хань нөхөрт марташгүй муу үгсийг бүү хэл.
Үгээ үл сонсох хүмүүнд олон сургаал бүү захь.
Үнэхээр зүтгэсэн ардын урмыг өчүүхэн юманд уурлаж бүү шантал,
Үзмэгцээ яаран магтаж гайхуулах ахул
Удалгүй хэрэлдэн салаад
Даруй буцаж ирээд инээн явагч
Үзтэл муу ард мөний тул урьдаас зайл.
Дээрэнгүй омогтой сэтгэлийг бариад,

Дэмий муу биеэ гайхуулаад,
Дээдсийн ёсоор загнагч
Танхай ичих мэт түүнээс үтэрхэн зайл.
Хилэн ихтийг аргаар өнгөрүүл,
Хилэнц ихтийг ном буянаар тэтгэ.
Төрөл төрөгсөдөө өргөж бөх их хүчтэй болох,
Төв ихсийн ёсоор дагаж хүмүүнд их нэртэй болох,
Үүнийг түүнийг ялгалгүй асарч олон их нөхөдтэй болох,
Төв ихсийн журмыг дагаж түмнийг эхлэх,
Холын хүмүүнд өршөөл тусыг хүргэж
Алдар нэрийг дуурсах,
Ойрын хүмүүнд асрал өглөг хүртээвээс
Эеэ олох бөгөөд хүч нэммүй.
Харийн газар нэр чадлыг бэхэл.
Халуун зуур эе сургаалаа хичээ.
Номын шажинд дургүй сахилтнаас
Сайн сүсэгтэй хар хүмүүн дээр гэлээ,
Төр үл мэдэх хаадаас
Төвшин сайн төр мэдэх түшмэл дээр гэлээ,
Ичгүүр үл мэдэх хатнаас
Ичгүүр мэдэх шивэгчин дээр гэлээ.
Хадгалж үл чадах хөвгүүнээс
Халамжит сайн боол дээр гэлээ.
Харам сэтгэл тушаа,
Хатуу сэтгэл жад,
Хар санаа хор мэт.
Ханилсан нөхрөө хуурваас,
Харин биеэ хуурсан мэт больюу.
Муу хүмүүнд үлэмж олон үг бүү захиж хэл,
Харин улиг болмуй.
Учир үл мэдэх хүмүүнтэй үг бүү тэмц,
Харин ичгүүр болмуй.
Омогтой өчүүхэн номч
Үргэлж их мэдэх мэргэдэд халдваас
Түргэн шантрахын тэмдэг,
Гэнэт сайжирсан хүмүүн
Хэтэрхий ихэст халдваас
Гэмшиж үл барагдахын тэмдэг.
Арслангийн омог мөн арсланд зохих.
Арслангийн баатар үнэгэнд тусгүй.
Арслан үнэг мэт явбаас түргэн гутах.
Үнэг арслан мэт явбаас түргэн үхэх.
Хэмээсэн энэ үлгэрийг хянан үзэж,
Хэн хүмүүн хэр хэрээ мэдэж
Чинээ чинээгээ бодож явсан сайн.
Ер хоёр хүмүүн ч болов зетэй болбоос
Төмөр хүрээ мэт бэх.
Хорин хүмүүн ч болов эвгүй болбоос
Эвдэрхий хүрээ мэт хялбар.

Өнөр хүмүүн эвгүй болбоос
Өнчин хүмүүний элэг.
Олон хүмүүн эегүй болбоос
Оорцог хүмүүний идэш болью.
Цувж явсан барсаас
Цугларч суусан шаазгай дээр гэлээ
Иймийн тул, эеэ хичээ.
Нэн үлэмж болгож явагтун.
Амраг ханилсан нөхөрт
Ааван хүмүүний үгээр бүү уурла.
Онож мэдэж,
Харин анхааран биеэ шинжигтүн.
Үлэмж ханилсан хүмүүнийг муу сэтгэлт хүмүүн үзэн ядаж
Аргаар хутгаж байж эвдрүүлээд
Элэглэе гэх мэдэшгүй
Үүнийг хичээн санах хэрэгтэй.
Ер өнгөч зусар аргатай муу хүмүүн
Зөөлөн худал үгээр хуурч байж
Үнэнхүү санааг аваад
Үймтэл муутган хэлэх нь олон буй.
Үзтэл таньж ханилсан
Үнэн худал үгсийг тэвч.
Хүмүүнд мэдэгдвээс бие хөнгөрмүй.
Бардам хатуу үгийг орхи
Хүмүүн мэдвээс хөшимүй.
Хулгай худлыг ердөө тэвч,
Энэ насанд ичгүүр болох.
Эцэс хойдод тамын буг болох,
Үүнийг урьдаас тасал,
Ариун явалтай ламыг бурхан мэт тахь.
Асрал ихт эзэд ноёдыг тэнгэр мэт хүндэл.
Ам авсан тангаргийг амь мэт сахь.
Арга залиг угаас орхи.
Аливаа хүмүүнтэй бүү тэнсэлт.
Сайд хүмүүнтэй бүү эвдэр.
Лам хүмүүний эд малд бүү хурьц.
Дэмий л хүмүүнийг бүү аргад.
Өчүүхэн бага хүмүүнийг бүү бас.
Самуун сэтгэлийг бүү үүсгэ.
Бурхан тэнгэр хоёрыг тахь.
Ноёд сайдыг бүү хараа.
Айх ичихийг ажиглаж мэд.
Дотор муутай төрлөөс
Тун үл таних хүмүүнтэй ханилваас дээр гэлээ.
Ухаан муутай ах дүү дайсантай адил гэлээ.
Өрсөх дайсанд цусаа бүү үзүүл.
Өшөөтэй хүмүүнд муугаа бүү үзүүл.
Хортон хол ойр үгүй биш үү.
Хэн хортой бөгөөс шадар гэж бүү янагла.

Хэн тустай бөгөөс гадуурхаж бүү ялга.
Зөвтэй явах хүмүүнийг бүү дар,
Буруутай явах хүмүүнийг бүү асар.
Муу ардыг их асарваас
Харин биед халдах гэм буй.
Сайн ардыг муулваас хойно гэмших буй.
Үнэн худал, сайн мууг ялгаж мэдвэл их хэрэгтэй.
Хэдий их өргөмжилвөөс өчүүхэн сэтгэлийг барьж олонтойгоо зохь.
Гэнэт доройтвоос гайхалгүй мэдэх хэрэг.
Хүмүүний нүүрийг харалгүй
Үйлээ туйлд хүртэл зүтгэж мэдэх хэрэг.
Харийн үйлд сэрэн,
Халуун зуураа эе эвээ хичээн санаж явагтун.
Дээдсийг хүндэл, доодсыг асар.
Бурхны шажинд амь биеэ тавь.
Бусдын тусад биеэ орхи.
Бултралгүй явбаас богд сайдын явдал ойр гэх.
Самуун муу биеэ ихэд бодоод,
Сайн хүмүүнийг үзэн ядаад,
Саваагүй мунхаг үгээ зөв болгоод,
Хаан дор эзэн их төрийг бариад
Аргалан авч хууран идэхийг сурч,
Доорд хүмүүнийг дарлан явагч хүмүүн
Адгуусны зэрэгт ойр гэх буюу.
Илт нүүр дээрээ магтаад далд муулаад,
Их өгвөөс баярлаад,
Эс өгвөөс гомдоод
Инээд наадмаар өнгөрүүлээд
Ичгүүр үгүй ятгаж сургаалд үл орох
Хүмүүнийг гэсгээвээс улам хойддоо тустай буй.
Өөрийн хэргээ орхиж
Үнэн санаагаар зүтгэж
Ил далд магтаал ба муудлыг үл бодон,
Олзонд шуналгүй
Нэгэн зоригоо хугалалгүй,
Ер уйдах чилэхийг саналгүй
Хэв хичээн цөхрөл үгүй,
Зовох цагт зайлах үгүй,
Жаргах цагт хэтрэл үгүй,
Хайрлах цагт тэнсэл үгүй,
Хатуужлын цагт гомдол үгүй,
Насан үргэлж нэгэн зангаар явагч
Үзтэл сайн хүмүүн билээ.
Гэмтэй хүмүүнийг хайрлаваас
Улам хойтдоо хөгжил болох бөлгөө.
Ер хүмүүний муу үйл яршигтай тул,
Амьтны сэтгэл мэдэшгүй
Зальхай хуурамч аргатай нь олон бөгөөд хардашгүй яахан баримтлах буй.
Тустай санааг насад хичээж яв.

Тустай хүмүүн ус мэт.
Тун муу хүмүүн мод мэт.
Бусдын гэм ичгүүрийг нууж орхи.
Өөрийн биеэ магталгүй
Үйлээ үргэлж шинжигтүн.
Шажины тусыг цаг тутам үйлдэж явбаас
Хэв хэзээ зуун замд үхэлгүй насны шидийг эс олсны тул
Мөнх бусыг санах хэрэгтэй.
Аюултай тамын хаалгыг эс хаасны тул
Хилэнцээс зайлах хэрэгтэй.
Ашдын хүнс өглөгийг өгөх,
Амгалан дээд орны мөр нь
Лам гурван эрдэнэ.
Мэргэдийн гэгээнийг үзэлгүй ном номлогч,
Ноёдын гэгээнийг танилгүй төрийн ёсыг хэлэгч
Энэ хоёр эндүүрчээ.
Гэм хийвээс цааз бэрх,
Хилэнц үйлдвээс там бэрх,
Жаргал зовлон бүгд
Ач үрийн хувь,
Ашдын амар жаргалыг олъё гэвээс
Онц буян хэрэгтэй тул хичээн үйлд,
Эрдэнэт ламын тангарагийг бүү эвд.
Эзэд хаадын зарлигаас бүү дав.
Эцэг эхийн сургаалыг бүү март.
Эм хөвгүүн хүүхэд боолын үгийг бүү дага.
Шударга үгийн сургаал үүгээр элдэв жаргалан үүсэх болтугай.
Үүнээс үлэмж сударт номлосон нь,
Сонсохын дээд олноо өргөгдөх,
Жаргалангийн дээд сэтгэл амар.
Нөхрийн дээд үл хуурах,
Үйлийн дээд бодь мөрийн зэрэг,
Хортой бөгөөс хүмүүнийг ч тэвч.
Тустай бөгөөс дайснаа ч асар.
Үлэмж олон од бий боловч
Ганц зулын гэрэл шөнөдөө хэрэгтэй хэмээгчийн үлгэр нь,
Олон хүмүүн буй боловч
Олон цугласны дотроос ганц сайн хүмүүн удирдан хэлэх,
Алтан дэлхийг үргэлж өргөстэй гэж үл болох
Өөрийн хоёр хөлөө бэхэлсэн дээр гэлээ, хэмээгчийн үлгэр нь,
Олон мунхаг ардыг сургаснаас ганц биеэ сургасан дээр гэлээ.
Тэргүүнийг огтлон чадах ноёд
Улс албат юугаа тэжээн чадах хэмээгчийн үлгэр нь,
Гэмтнийг гэсгээвээс түмэн хүмүүнийг жаргуулан чадах хэмээгчийн үлгэр нь,
Жаргахын цагт сэрэх хэрэгтэй.
Зовохын цагт хатуужих хэрэгтэй.
Дайсангүй гэж ирт мэсээ биеэс бүү холдуул.
Даруй хортой хэмээн нөхрөө бүү сөнөө.
Онож мэдсэн нь хэрэгтэй.

Алтыг түлвээс улам өнгө гарах,
Нүүрс нухваас улам харлах,
Муу хүмүүн нэг ч эрдэмгүй болбоос
Гагцхүү дээрээ шүдтэйгээс бус үхэртэй адил.
Сургаалыг үл сонсох хүмүүн гагцхүү цадахыг хүсэгч хүмүүн
Үс үгүйгээс нохой дор адил.
Муу хүмүүнд хүргэсэн тус хужиртай газар тарьсан тариа ба
Турууны нууж тавьсан хүнс
Тэр гурвууланд хэрэглэхээс бусдад тус үгүй.
Бус юмыг засаж болох
Муу хүмүүнийг засаж үл болох хэмээжээ.
Олон бүгд архи уусныг жаргал хэмээдэг.
Ааралжилан явах өвчинтэй хүмүүнийг жаргалд тооцох буюу.
Муу хүмүүний хэрэгт зарваас өвчин хүртэх буюу.
Аргагүйд зарваас хойноос бас явах,
Хэрэв аян хийвээс өмнө урагшлан гарч
Шал бул худал өгүүлэх.
Эцэг эх юугаа хууран бүрэлгээд,
Үүнээс түүнээс гуйж эс өгөв хэмээн
Худал өгүүлэн хэрүүл үүсгэж,
Харин гутаах.
Эмээ дагаж төрхөмд нь заруулах.
Өр шир хийж төрөл төрөгсдөө үл амруулах
Хулгай худал хийж амиа өргөх
Ийм зовлон бүгдийг өөрийн зоригоороо үйлдээд
Ах дүү нар аль гэх,
Ер хүмүүний төрлийг олсон тул
Түүнээс зайлах хэрэгтэй.
Хэрэв эс суравч хойдын авъяас болох тул
Хичээн суртугай.
Адгуус бээр эрдмийг сурах бөгөөтөл,
Эрдэнэт хүмүүний төрлийг олсон болоод
Хүмүүний сурсан эрдмийг болгоомжгүйгээс бус
Болгоомжтой бөгөөс эрдэм сурах хялбар.
Үхэхийн урьд амьд цагтаа буяныг үйлд.
Өтлөхийн урьд залуу цагтаа эрдмийг сурагтун.
Өвчин хүртэхийн урьд эрүүл цагтаа номыг хичээн
Үгүйрэхийн урьд баян цагтаа алдар нэрийг ав.
Бүтэхийн дөрвөн нөхөр тэр болой.
Хоосон чанарыг олсон ламыг тахь.
Хоёр заяаг ялгагч эрхэм түшмэлээр эзлүүлвээс
Хотол төгсгөсөн дагина учрах.
Хойд нутгийг дэлгэрүүлэн засах хөвгүүн төрөх.
Үхэх хүмүүн сайн ламаас айх.
Үгүйрэх хүмүүн сайн хоточ нохойноос айх.
Доройтох ноёд сайн түшмэлээс айх.
Маш зөвөөр явбаас сайн алдар нэр нь
Мөн энэ биеийн чихэнд сонсогдох хэрэг.
Арга билиг хоёрыг алган дээрээ тогтоох,

Мөн асар ховдогловоос тамираа мэдэгдэх,
Борооны ус түргэн өнгөрөн урсавч үтэр замхарах,
Их мөрөн дөлгөөн урсавч их далай болох,
Чин сайн эрдэмт хүмүүн
Хонь чоно хоёрыг нэгэн онгоцонд услах мэт.
Чингис богдын байгуулсан шастир үүнээ
Элдэв шажин төр энх амгалан тогтох болтугай.
Нэгэн сайн аяа гайхамшигт үлгэр үүнийг
Танхай ард өөрчлөн шалгаад
Сайн ухаж явбаас жаргал эдлэх.
Энэ цагтай нийлэх шастир мөн тул
Оюун түлхүүр нэрт шастир сурах хэрэгтэй болой.
Үлгэр нь мэргэд эрдэнийн хэлтэрхийг шинжих.
Бүдүүн нүүрсийг хаана шинжмүй.
Жигүүртний хаан Хан гаруди нар гарахыг таалмуй.
Жич муу хар элээ бүрий болохыг таалах.
Цаст уулын цагаан арслан хар ууланд үл одох зан,
Сарьсан багваахай шөнө нисэх зан,
Их галт хорхой ертөнцийг дүүргэх гэрэлтэй боловч
Гагцхүү нарны гэрэлд дарагдах.
Сайн толийг эс арчваас өнгө үл гарьюу.
Цагаан лавайг эс үлээвээс дуу үл гарах.
Эрдэнэ биеэ элэгдтэл үг гарах.
Эрдэмтэй сайн хүмүүн зовох цаг тутам жаргадаг гэлээ.
Эрдмийг хичээвээс нэр алдар хаана ч алдарших буй.
Гэм эрдмийг эс ялгаж танисны үлгэр нь,
Мунхаг ухаант мэргэд
Сармагчин хөтөлсөн хүмүүнийг хүндлэв гэх адил.
Ийм иймийг язгуурын эрдэм лугаа сэлбэн ав.
Эрдэм сурахгүй бөгөөд,
Арга хуурмагийг сурч идэхийн үлгэр нь,
Нэгэн хүмүүн тариалангийн хэргүрээс айх
Нэгэн илжигээ барсын хуучин арьсыг өмсөж тариа дор тавьснаас
Барсын арьс салхинд хийссэнийг
Бүгдээр илжигийг таньж,
Эзэнтэй нь хамт алав гэх.
Үнэн эрдэм алтанд адил.
Алтыг түлвээс улам сайхан өнгө гарах.
Мий муур эрхи зүүьюү
Махнаас байв гэж
Хулгана барьж идээд мэдэгдэв гэх
Үнэгний гэмийг хэлээд харин үнэгэнд хэлэгдэв гэх.
Галыг уруу хандуулваас
Харин гар өөд шатах болмуй.
Эрдэмтэй болбоос гүрэн их олон нь хүндлэх.
Эрдэм эс сурваас доромжлогдон, басагдах хэмээгчийн үлгэр нь,
Өлссөн барсын дэмий хүрхрэх дуунд,
Модны ой дунд хэвтсэн сармагчин өөрөө хөсөр унаж идэгдэв гэх.
Пагжил улсын хөвгүүн,

Хамаг дайсныг дарав гэх.
 Шоргоолж бүх газрыг цоолох чадалтай.
 Сайн хүмүүн хамгийг хураах чадалтай.
 Үхэр хараацай хөсөр газрын ус үл уух.
 Арслан бөөлжсөө үл идэх,
 Сайн хүмүүн үгээ үл урвах.
 Харин хамаг нөхдөө тэтгэх буй.
 Энэ ба хойд хоёр жил буяныг хураах болжуу.
 Төмрийн хан соронзон гүр төмрийн үртсийг авах дор адил.
 Сайн хүмүүн үг авч мэргэдийн сан болох.
 Шагжийн хөвгүүн Шигэмүни
 Хамаг эрдмийг сурсны тул,
 Туулсан бурхан болж
 Хамаг шажныг дэлгэрүүлэн,
 Хамаг судар дандарсыг бадруулсан нь,
 Баршгүй энэ номын тивд учирсан
 Эрдэнэт хүмүүний биеийг олсон нь маш чухал чухаг больюу.
 Энэ биеийн цогц энэ буй цаг дор
 Шатыг улам дээш тавьж гаргахуй дор адил.
 Өчүүхэн шастираас улам ахуй их номыг төгс сурч алдаршсан
 Номын чанар олох болтугай.
 Чингис богдын зохиосон Оюуны түлхүүр нэрт шастир ийн төгсөвэй.
 Сайн буян арвидан дэлгэртүгэй.
 Хотол бүхнээр амаржих болтугай.
 Ум мани бадмэ хум.
 Мангалам.

Монголчуудын дунд өргөн тархсан «Оюун түлхүүр» сургаалын гар бичмэл эхүүдийг эрдэмтэд хэвлэн нийтэлсэн байдаг. Тухайлбал, академич Ц.Дамдинсүрэн 1959 онд «Оюун түлхүүр» сургаалын XX зууны эхээр Улаанбаатарт хэвлэгдсэн хоёр хэвлэл, мөн таван зүйлийн гар бичмэлийг тулган нягталж хэвлүүлсэн.² Мөн Халимагийн эрдэмтэн А.В.Бадмаев 1991 онд ойрад хэл дээр «Оюун түлхүүр»-ийн 4 хувилбарыг судалж, халимаг хэлнээ хөрвүүлж, галигтай нийтлүүлсэн.³ Оросын монгол судлаач Н.С.Яхонтова «Оюун түлхүүр»-ийн тод үсгийн хувилбарыг бусад эхээс нэлээд онцлогтой гэж үзээд, эрдэм шинжилгээний галиг, орос орчуулга, тайлбарын хамт хэвлүүлжээ.⁴ Профессор Ш.Чоймаа 2007 онд академич Ц.Дамдинсүрэнгийн хэвлүүлсэн «Оюун түлхүүр» сургаалыг үндэс болгоод, Н.С.Яхонтовагийн хэвлүүлсэн тод бичгийн эх зэргийг харьцуулан хөрвүүлж, тод бичгийн эхээс нөхөн тодотгож, үг хэллэгийн тайлбар хийж кирилл, монгол хос бичгээр хэвлүүлэн⁵ олны хүртээл болгожээ.

² Дамдинсүрэн Ц. Монгол уран зохиолын дээж зуун билиг оршвой. УБ., ШУАХ. 1959. 58 дахь тал.

³ Дам ишлэв. Бадмин Андрей. Тод үзгин «Оюн түлхүүр» хойр текст. // Теегин герл. 1991. №6, 7.

⁴ Яхонтова Н.С. «Ключа разума» (ойратский текст). //Mongolica-V. СПб., 2001, С.38-53., Ойратский перевод «Оюн түлхүүр» //Тюркские и монгольские письменные памятники. Текстологические и культурологические аспекты исследования. М., 1992, С.137-152. 26., Yakhontova N.S. "The Oyun tülkigür" or "Key to Wisdom": Text and translation based on the MSS in the Institute for Oriental Studies at St. Petersburg //Mongolian Studies. (Bloomington) Vol. 23 (2000). pp. 69-138.

⁵ Оюун түлхүүр нэр шастир оршвой. Эхийг харьцуулан, кирилл үсэгт хөрвүүлж, тайлбар хийсэн Чоймаа Ш. Хянан нягталсан Заябаатар Д. УБ., МУИС-ийн хэвлэх үйлдвэр. 2007. 6 дахь тал.

Миний нагац ах ХХ зууны эхэн үед хуулагдсан «Чингис богдын зохиосон сурагч ардын ухааныг хөглөх Оюуны түлхүүр»⁶ гэсэн гар бичмэлийг хадгалж байжээ. 2018 оны 8-р сард уг гар бичмэлтэй танилцан кирилл бичигт хөрвүүлж уншигч Танаа толилуулж байна.

Гар бичмэл нь дэлгэрэнгүй ба хураангуй хоёр гарчигтай байх бөгөөд төгсгөлийн хэсэг нь өмнө хэвлэгдсэн эхүүдээс ялгаатай. Энд хэн нэг зохиогч, бичээчийн нэр дурьдаагүй байна. Уг сургаалын хэвлэгдсэн эхүүдийг ажиглахад, зарим үг хэллэг, мөр, бадгийн ялгаа буй. Зөвхөн нэг жишээ дурьдахад, уг гар бичмэлд “Энэ биеийн цогц энэ буй цаг дор”; академич Ц.Дамдинсүрэнгийн хэвлүүлсэн «Оюун түлхүүр»-т “Олохуйяа бэрх энэ цогцоо бүхий цагт”; Н.С.Яхонтовагийн хэвлүүлсэн «Оюун түлхүүр хэмээх туужийн судар оршивой»-д “Энэ биеийн цогц энэ буй энэ цагт” гэсэн буй. Энэхүү хөрвүүлэг цаашид монголчуудын сэтгэлгээний түүхийн судалгаанд ашиглагдана хэмээн найдаж байна.

⁶ *Činggis boyda-yin joqiyaysan surayči arad-i uqaan-yiγ kōyekōlekō oyun-u tülkeyür. Гар бичмэл эх. Онгүй.*